




## АРДЧИЛЛЫН ҮНДЭС ХӨТӨЛБӨР

Ардчиллын Үндэс хөтөлбөр нь шударга ёс, үүрэг хариуцлага, эрх мэдэл, хувийн эрх чөлөө гэсэн ардчиллын суурь үнэт зүйлсийг сурагчдад эзэмшүүлснээр тэднийг чадвартай, мэдлэгтэй, хариуцлагатай, бүтээлч иргэн хүн болгон төлөвшүүлэх зорилготой юм. Бидний үүрэг бол сурагчдад өөрсдийн ухаалаг сонголтыг хийх чадварыг хөгжүүлэхэд нь туслах юм. Юу хийх ёстойгоо бодохоос илүүтэй хэрхэн бодож тунгаах чадварыг хөгжүүлэх нь чухал. Ийм зарчмаар суралцах нь ардчилсан нийгмийг хамгаалах ба сайжруулан хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай зарчим, явц, үнэт зүйлсэд ухаалаг, зохистой хандах хандлагыг төлөвшүүлж чадна.

Энэхүү хөтөлбөр нь

-  Үндсэн хуульт ардчилсан нийгмийн байгуулал болон ардчиллын суурь зарчим, үнэт зүйлсийг ойлгуулах
-  Хүүхэд залуучуудын идэвхитэй, хаируцлагатай иргэн болоход зайлшгүй шаардлагатай ур чадварыг хөгжүүлэх
-  Хувийн болоод нийгмийн амьдралд шийдвэр гаргах, асуудал, зөрчилийг зохицуулахдаа ардчилсан арга замыг хэрэглэх ойлголт, хүсэлтэй болгоход чиглэсэн болно.

Ардчиллын Үндэс Цуврал нь

1. “Төгөлдөр үүрэг хариуцлагад суралцсан нь”, “Бамбаруушнууд шударга ёсонд суралцсан нь”, “Алтайхай эрх чөлөө нөхөрлөлд суралцсан нь”, “Дарам Дэрэм хоёр эрх мэдэлд суралцсан нь” нэр бүхий сургуулийн бага ангийн 1-3 дугаар ангийн хүүхдэд зориулсан дөрвөн цуврал зурагт уншлагын ном.
2. “Төгөлдөр үүрэг хариуцлагад суралцсан нь”, “Бамбаруушнууд шударга ёсонд суралцсан нь”, “Алтайхай эрх чөлөө нөхөрлөлд суралцсан нь”, “Дарам Дэрэм хоёр эрх мэдэлд суралцсан нь” гэсэн дөрвөн цуврал номын багшийн гарын авлагаас бүрдэнэ. Гарын авлага нь 4-6 хичээлийг хэрхэн заах аргачлал, санаа, дасгал ажлууд, дүрд тоглох, асуулт хариулт, дүгнэлт дасгалууд болон сурагчдын ойлголтыг үнэлэх дасгалыг багтаасан болно.
3. Хичээлийн бус цагаар эцэг эхчүүд ч хүүхдүүдтэйгээ хамт уншиж судалж болно. Гэхдээ дээр дурдсан үнэт зүйлсийг хандлага болгох гэдэг зарчмыг мартаж болохгүй.

## **БАГШИЙН ГАРЫН АВЛАГА**

### **БАМБАРУУШНУУД ШУДАРГА ЁСОНД ХЭРХЭН СУРАЛЦСАН НЬ**

#### **Шударга ёсны зарчмыг танилцуулах нь**

Сонин уншихад эсвэл телевизийн нэвтрүүлэг үзэхэд шударга бус явдлын тухай жишээ, хэн нэгэн хүн болон бүлэг хүмүүс шударга бус үйлдэл юм уу хуурамч бараа материал, шударга бус хандлагын талаар гомдоллох, эсвэл хууль зөрчсөн шударга бус этгээдийг шүүх хурлын талаар уншихгүй буюу үзэхгүй өнгөрөх бараг боломжгүй юм. Яагаад ийм байдаг юм бэ? Үүний нэг тайлбар нь улс төрийн болоод хууль зүйн үндсэн суурь баримт болох Тусгаар Тогтнолын Тунхаг болон Үндсэн Хуульд манай нийгмийн шударга ёсны төлөөх хүсэл тэмүүлэл тунхаглагдсан байдагт оршино.

Шударга ёсны тухай энэхүү ном нь хүүхдүүд өөрсдөө тодорхой нөхцөлд шударга ёсны асуудлыг тодорхойлж, шийдвэрлэж үзсэнээр шударга ёсны суурь зарчмуудыг ойлгож авахаар боловсруулагдсан болно. Хүүхдүүд орчин үеийн бодит амьдрал дээр шударга ёсны чухлыг улам илүү мэдэрч, шударга ёсны асуудлыг үр дүнтэй ба ухаалгаар шийдвэрлэх хандлага болон ур чадвар нь нэмэгдэнэ.

Шударга ёсны хичээлийг судалснаар тэд шударга ёс болон зөв байх гэдэг ойлголт нь бараг нэг ижил ойлголт болохыг мэдэж авна. Түүнчлэн бараг хүн бүр өдөр тутмын амьдралд гэртээ, сургууль дээр, эргэн тойрондоо шударга ёсны асуудалтай тулгарч байдгийг ойлгоно. Шударга ёс хэмээх өргөн хүрээтэй ойлголтыг илүү сайн ойлгуулахын тулд хөтөлбөр шударга ёсны асуудлуудыг шударгаар хуваарилах, буруу үйлдлийг шударгаар засч залруулах, шударгаар шүүн хэлэлцэх гэсэн ойлголтуудад хуваан авч үзсэн юм. Энэ нь бидэнд асуудлыг шүүн тунгааж шийдвэр гаргахдаа “оюуны аргачлал” гэж нэрлэсэн бүлэг асуултыг хэрэглэхэд туслах юм. Хичээлийн туршид хүүхдүүд шударга ёсны төрөл бүрийн асуудлыг шүүн тунгаан шударга, зөв шийдвэр гаргаж сурна.

Ийм чухал асуудлыг бага насны хүүхдэд ойлгуулах нь мэдээж түвэгтэй. Тиймээс бид Бамбаруушнууд шударга ёсонд суралцсан нь өгүүллэгийг 4 бүлэгт хуваасан билээ. Бүлэг бүрт шударга ёсны ойлголтын нэг чухал зарчмыг заахаар төлөвлөсөн юм.

## АГУУЛАГА

### **Нэгдүгээр бүлэг - Шударга ёс гэж юу вэ?**

Шударга ёс гэдгийг зөв сайн байх гэж ойлгож болно. Шударга ёсны асуудлыг 4 ангилдаг. Хуваарилалт \бусадтай хуваалцах\, засч залруулах \буруутай болон хор уршигтай үйлдэлд хариу өгөх\, шүүн хэлэлцэх \мэдээлэл цуглуулан шийдвэр гаргах\

Багшийн гарын авлага - Хуудас 5

### **Хоёрдугаар бүлэг - Бусадтай эд юмсыг хэрхэн шударгаар хуваалцах вэ?**

\Хуваарилалт\

Хүүхдүүд шударга хуваарилалт гэдэг нь үргэлж ижил тэнцүү хуваана гэсэн үг биш гэдгийг ойлгоно. Юмсыг хуваарилахдаа тухайн хүний хэрэгцээ, чадвар, хүртэх эрхийг харгалзах ёстой юм байна гэдэгт суралцана.

Багшийн гарын авлага - Хуудас 8

### **Гуравдугаар бүлэг - Буруутай болон хор уршигтай үйлдэлд хэрхэн шударга хариу өгөх вэ? \Засч залруулах\**

Энэ бүлэгт шударга хариу өгөх нь юмсыг зөв байдалд буцаан оруулах болон дахин буруу болон хор хохиролтой үйлдэл давтагдагдахгүй байхаас сэргийлэхэд чухал болохыг харуулна.

Багшийн гарын авлага - Хуудас 11

### **Дөрөвдүгээр бүлэг - Мэдээлэл олж авах ямар шударга арга байна вэ? Шийдвэр гаргах ямар шударга арга зам байна вэ? \Шүүн хэлэлцэж шийдвэрлэх\**

Хүүхдүүд шударга аргаар мэдээлэл цуглуулан шийдвэр гаргах нь ямар чухал болохыг мэдэж авна. Тэд шүүн хэлэлцэх журмын суурь ойлголтуудаас хэрэглэж сурна.

Багшийн гарын авлага - Хуудас 14

*НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
ШУДАРГА ЁС ГЭЖ ЮУ ВЭ?*

**Товч агуулга:**

Хүүхдүүд шударга ёс гэдэг нь зөв сайн байх гэдэгтэй адил ойлголт гэдгийг ойлгоно. Түүнчлэн зөв шударга байхыг бусадтай юмсыг шударгаар хуваалцах- шударга хуваарилалт, буруу болон хор хохиролтой үйлдэлд шударга хариу өгөх- засч залруулах, ямар нэгэн зүйлийг шударга аргаар олж авч, шийдвэр гаргах арга- шүүн хэлэлцэж шийдвэрлэх гэж хуваадаг тухай мэдэж авна.

**Хүлээгдэх үр дүн:**

Хүүхдүүд дараах чадварыг эзэмшинэ. Үүнд:

- Шударга ёс- зөв сайн байх гэдэг ойлголтуудыг ижил зүйл гэдгийг тайлбарлаж чаддаг
- болсон байна.
- Шударга ёсны гурван асуудлыг ялгаж чаддаг болно. Шударга хуваарилалт, буруу
- болон хор уршигтай үйлдэлд шударга хариу өгөх, мэдээллийг шударга аргаар олж аван шударга шийдвэр гаргах

**Хичээлд бэлтгэх ба шаардлагатай материал:**

“Бамбаруушнууд шударга ёсонд суралцсан нь” ном, Нэгдүгээр бүлэг, Хуудас 1-11

- Гарын авлагын арын хуудсанд байгаа өнгөөр будах дүрүүдийн баг
- Зургийн цаас, өнгийн харандаанууд
- 

**Түлхүүр үгс: Шийдэх, шударга ёс, хариу өгөх, санал хураах**

**Тайлбарлан ойлгуулах санаанууд:**

Нэгдүгээр бүлэгт шударга ёс гэдэг нь зөв сайн байх гэдэгтэй адил ойлголт гэдгийг танилцуулна. Шударга ёсны гурван төрөл байдаг. Үүнд: бусадтай юмсыг шударгаар хуваалцах- буюу шударга хуваарилалт, буруу болон хор уршигтай үйлдэлд шударга хариу өгөх буюу засч залруулах, ямар нэгэн үйлдлийг шүүн тунгааж хэлэлцэхдээ мэдээллийг шударга аргаар цуглуулан шийдвэр гаргах буюу шударга, зөв шийдвэр гаргах журам багтана. Хүүхдүүдэд эдгээр санааг өдөр тутмын амьдралд тохируулан хэрэглэх тухай заана. Шударга ёсны эдгээр санаанууд тэдний гэр бүл, сургууль, орон нутагт хэрхэн нөлөөлж байдаг тухай хүүхдүүдээс асууна.

